



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/106

Ховд

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хороонуудын шалгаруулалт, дүгнэлттэй холбоотой тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хуульд заасны дагуу дахин магадлаж дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч : Т.Жаргалсайхан

- Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүн : Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль эрх, зүйн хэлтсийн дарга

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ч.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль эрх, зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн


Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хуульд заасан хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэн ажлын хэсгийн дүгнэлтийг тухай бүрт нь танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 07 0553
D/Zah-A/106-Bo